


Шивээ овоо ХК (SHV.MSE)

2012/09/04

Салбар: Уул уурхай-Нүүрс

Хувьцааны үнэ



Үзүүлэлтүүд

Симбол	SHV
Хувьцааны код	460
Нийт гаргасан хувьцаа	13,419,101
Зах зээлийн үнэ 2012.09.04	9,000
Зах зээлийн үнэлгээ (тэрбум төгрөг)	120,7

	2010	2011
Цэвэр ашиг (тэрбум төгрөг)	12.57	- 2.40
Нэгж хувьцаанд ногдох ашиг (EPS)	936.58	- 179.13
Үнэ ашгийн харьцаа (P/E)	9.11	147.2
Нийт хөрөнгийн өгөөж(ROA)	0.14	0.03
Эзэмшигчдийн өмчийн өгөөж (ROE)	2.57	0.12
Нэгж хувьцааны ногдол ашиг (DPS)	-	-
Ногдол ашгийн өгөөж		
Дундаж хувьцааны үнэ	8,527.8	26367.73
Дундаж зах зээлийн үнэлгээ (тэрбум төгрөг)	114.44	353.83

Эх сурвалж: Стандарт инвестмент ХХК

Судалгааг бичсэн:

Цэдэвдорж ЧИМГЭЭ,

Судалгааны багийн ахлагч

chimgee@standardinvestment.mn

T +976 701 14433

M +976 99066293

Бямбаа МӨНХТУЯА,

Судалгааны ажилтан

munkhtuya@standardinvestment.mn

T +976 701 14433

M +976 99027432

Компанийн тойм

Танилцуулга

Шивээ-Овоо ХК нь 1990 онд Шивээ-Овоо уурхай нэртэйгээр үүсгэн байгуулагдаж, Монголын хөрөнгийн биржид 1995 онд бүртгүүлэн хувьцаат компани болжээ. Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний орд нь Улаанбаатар хотоос зүүн урагш 260 км-т Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын нутагт байрладаг ба Монгол Улсын дотоодын хэрэгцээний нүүрсний 25 хувийг дангаараа хангадаг. Шивээ-Овоо уурхай нь 1993 оноос жилд 500,000 тонн, 2003 оноос жилд 2 сая тонн нүүрс олборлон борлуулах хүчин чадлаар ажиллаж байна. Одоо ашиглаж байгаа хэсгийн нийт нөөц нь 646.5 сая.тн бөгөөд өнгөрсөн хугацаанд 14.5 сая шоо метр хөрс хуулж, 7.4 сая тн нүүрс олборлон борлуулжээ. Компанийн нийт ажиллагсадын тоо одоогийн байдлаар 350 гаруй юм.

Хувьцаа эзэмшигчид

Засгийн газар	90%
Мастер фонд II	5%
Бусад	5%

Менежмент

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б. Сүхбаатар

Банзарын Сүхбаатар нь Санхүү эдийн засгийн техникум, Монгол улсын их сургуулийг дүүргэн, 1976-1990 онд Нефть хангамжийн удирдах газарт ня-бо, орлогч ня-бо, санхүүгийн хэлтсийн дарга, 1990-1994 онд Нефть импорт хангамжийн нэгтгэл, Нефть импорт концернд санхүү эрхэлсэн дэд захирал, 1994-1996 онд НИК тос ББХК-нд захирал, 1996-2002 он НИК ХХК-д тэргүүн дэд захирал, 2002-2006 онд МУЗН-т санхүү, аж ахуй эрхэлсэн дэд даргаар тус тус ажиллажээ. 2006 оноос Төрийн өмчийн хороонд Төрийн өмчийн бүртгэл, хяналт шалгалтын газрын даргаар ажиллаж байна. Мөн Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын үүргийг хийж байна.

Гүйцэтгэх захирал Х. Балсандорж

Хөхөөгийн Балсандорж нь 1986 онд ЗХУ-ын Свердловск хотын Уул уурхайн дээд сургуулийг Уулын цахилгааны инженер мэргэжлээр төгсөж, ТЭХҮЯ-ны томилолтоор Багануурын нүүрсний уурхайд ажиллаж, 1995 оноос эхлэн Багануур ХК-ийн анхны гүйцэтгэх захирлаар, 2000-2004 онуудад УИХ-ын гишүүнээр, 2004-2010 оны хооронд "Монрок" ХХК-ийн ерөнхий захирлаар ажиллаж байгаад, 2010 оны 9-р сараас "Шивээ-Овоо" ХК-ийн гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байна.

Зах зээлийн мэдээлэл



Эх сурвалж: Ашигт малтмалын газар

Монголын үндэсний статистикийн хорооны мэдээллээр манай улсын ДНБ-ийн мөнгөн дүн сүүлийн жилүүдэд өссөөр байгаа бөгөөд 2011 онд 8.4 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд үүнээс уул уурхайн бүтээгдэхүүний мөнгөн дүн 2.2 их наяд төгрөг байжээ. Монгол Улсын нийт нүүрс үйлдвэрлэлийн хэмжээ 2011 онд 32 сая тонн байсан бол үүнээс төрийн өмчит нүүрсний уурхайн нийлүүлэлт 20 сая тонн, 2011 онд дотоодын нүүрсний хэрэглээ 6.8 сая тонн, экспортлосон нүүрсний хэмжээ 21.3 сая тонн болжээ. Ашигт малтмалын газрын 2012 оны нэгдүгээр сарын мэдээллээр эрчим хүчний нүүрс олборлогч компаниудын нийлүүлэлж буй нүүрсний үнэ 9,600-28,000 төгрөгний хооронд хэлбэлзэж байсан ба Шивээ-Овоо ХК-ний нүүрсний үнэ 15,560 төг/тонн байжээ.

Компанийн өсөлт, хөгжил

Монгол Улс нүүрсийг эрчим хүчний үйлдвэрлэлд гол түүхий эд хэлбэрээр ашигладаг ба одоогоор нийт цахилгаан, дулааны үйлдвэрлэлийн 90 гаруй хувийг зөвхөн нүүрс ашиглан гаргаж авдаг байна. Шивээ-Овоо ХК нь жилдээ 1.2-1.7 сая тонн нүүрс үйлдвэрлэж, Монгол Улсын нүүрсний хэрэгцээний 20 орчим хувийг ханган, төвийн эрчим хүчний системд харьяалагдах дулааны цахилгаан станцуудад нүүрс нийлүүлдэг стратегийн ач холбогдолтой уурхай юм. Доорх хүснэгтэнд Шивээ-Овоо нүүрсний уурхайн олборлолтын хэмжээ болон нийт олборлолтод эзлэх хувийг харуулав.



2009 оноос эхлэн Шивээ-Овоо ХК-ийн нийт нүүрс олборлолтод эзлэх хувь буурч эхэлсэн нь Монгол Улсын нийт нүүрс олборлолтын хэмжээ ихэсч байгаатай холбоотой. 2008 онд Монгол Улсын хэмжээнд нийт 10 сая тонн нүүрс олборлосноос Шивээ-Овоо ХК 1.45 сая тонн нүүрс олборложээ. 2011 онд энэхүү тоо 32 сая, 1.58 сая болж өөрчлөгджээ.

Монгол Улсын Засгийн газар 1996-2004 онд Япон Улсын Засгийн газраас 7.7 тэрбум иений (67.6 сая ам.доллар) зээл авч, Шивээ-Овоогийн уурхайд техник технологийн шинэчлэл хийх, хөрс хуулалтын хоцрогдлыг арилгах, нүүрс олборлолтыг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлсэн байна. 2010-2011 онд бутлах, хуваарилах хэсэгт 551 сая, нүүрс хатаах үйлдвэрт 3.3 тэрбум, конвейерийн байгууламжид 3.5

тэрбум, нийтдээ 7.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. Энэхүү хөрөнгө оруулалтын хүрээнд нүүрсний чийгшлийг багасган, илчлэгийг нэмэгдүүлж, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх, нүүрс тээвэрлэлтийн зардлыг бууруулж, бүтээгдэхүүний өөрийн өртгийг хямдруулах зорилго тавьж ажиллажээ. Шивээ-Овоо ХК нь цаашид нүүрснээс шингэн түлш боловсруулах үйлдвэр барихаар төлөвлөж байгаа ба төсөл нь судалгааны шатанд явж байна. Мөн Монгол, Хятадын засгийн газраас Шивээ-Овоогийн нүүрсний орд газарт 3600MW хүчин чадалтай 6-н цахилгаан станц шинээр барихаар төлөвлөжээ.

Дүгнэлт

Шивээ-Овоо ХК нь стратегийн гол уурхайдын нэг бөгөөд дүрмийн сангийн 90 хувийг нь төр эзэмшдэг. Одоогийн байдлаар Шивээ-Овоо уурхай нь 646.5 сая.тн бүхий хүрэн нүүрсний нөөцтэй. Шивээ-Овоо ХК нь одоогийн байдлаар “ДЦС-4” ТӨХК-ийн нүүрсний хэрэгцээг хангадаг байна. 2011 онд Шивээ-Овоо ХК нь 2.4 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн ба үүний шалтгаан нь 1.68 сая тонн нүүрс олборлох төлөвлөгөөний дагуу ажилласан авч “ДЦС-4” ТӨХК-нд 1.58 сая тонн нүүрс олборлон нийлүүлсэн байв. Ийнхүү алдагдалтай ажилласан тул 2010 онд 9.11 гэсэн үзүүлэлттэй байсан үнэ ашигийн харьцаа (P/E) нь 2011 онд -147 болж буурсан байна. Харин үнэ ба эзэмшигчдийн өмчийн харьцаа (P/B) нь 2010 онд 23.36 байснаас 2011 онд 18.03 болж сайжирсан байна. Учир нь 2011 онд компанийн зах зээлийн үнэлгээ харьцангуй их байсан хэдий ч эзэмшигчдийн өмч нь 15 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн тул P/B нь ийнхүү 18 болсон байна. Хөрөнгийн өгөөж (ROA) нь 2010 онд 14% байж салбарын хэвийн хэмжээнд байсан бол 2011 онд алдагдалтай ажилласан тул (-) утгатай болжээ. Эзэмшигчдийн өмчийн өгөөж (ROE) нь 2010 онд 257% байсан бол 2011 онд мөн алдагдалтай ажилласны улмаас (-) утгатай болсон байна. Шивээ-Овоо ХК нь 2011 онд алдагдалтай ажилласан хэдий ч цаашид төлөвлөгөөний дагуу ажиллаж бүтээгдэхүүн хүлээн авагчдаа бүрэн нийлүүлэлт хийж чадвал алдагдал хүлээхгүй ажиллах боломжтой юм. Шивээ-Овоо ХК нь байгуулагдсан цагаас өнөөг хүртэл ногдол ашиг тараагаагүй байна.

